



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Иргэний эрх зүйн маргаан¹)

ТЕСЛА КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ НЬ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙЖ ИЛОН МАСКИЙН КОМПАНИЙГ ХУДАЛДАН АВСАН НЬ ҮНЭНЧ ШУДАРГААР ШИЙДВЭР ГАРГАХ ЗАРЧИМД НИЙЦСЭН ГЭЖ ҮЗЭВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шийдвэрийн дугаар: 181, 2022

Шийдвэрийн огноо: 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Делавер мужийн Дээд шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Тесла компанийн гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, том хувьцаа эзэмшигч Илон Маск болон төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүд нь СоларСити компанийн дийлэнх хувьцааг эзэмшдэг хамаарал бүхий этгээдүүд юм. Тодруулбал, Илон Маск нь СоларСити компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, компанийн нийт хувьцааны 21.9 хувийг эзэмшдэг том хувьцаа эзэмшигч юм.

СоларСити компанийн 2015 оны санхүүгийн тайланд компанийн бэлэн мөнгөний урсгал багасаж, өр төлбөр нэмэгдэж, зээлжих зэрэглэл нь буурч, дампуурах эрсдэлд орсон болсон гэж дүгнэсэн. Ийнхүү СоларСити компани нь төлбөрийн чадваргүй болж, дампуурах эрсдэлтэй болсон учир 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Тесла компани нь СоларСити компанийн хувьцааг 2.6 тэрбум ам.доллараар худалдан авсан.

Нэхэмжлэгч Тесла компанийн жижиг хувьцаа эзэмшигчид **Илон Маскийг сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ өөрийн нөлөөгөө ашиглан нэгж хувьцааг зах зээлийн үнэлгээнээс дээгүүр үнэлж үнэнч шударгаар шийдвэр гаргах** (англ. Entire fairness standard), удирдлагын итгэл даах үүргээ (англ. Fiduciary duty) зөрчиж өөрийн хамаарал бүхий компанийг худалдан авсан хэмээн маргадаг.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Энэхүү шүүхийн шийдвэрээр сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ компанийн удирдлагын итгэл даах үүргээ зөрчсөн эсэх, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ үнэнч шударгаар шийдвэр гаргасан эсэхийг хянан шийдвэрлэсэн.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
<https://courts.delaware.gov/Opinions/Download.aspx?id=348500>



Анхан шатны шүүхийн шийдвэр²: Шүүхээс Илон Маскийг өөрийн хамаарал бүхий СоларСити компанийг худалдан авсан нь **үнэнч шударгаар шийдвэр гаргах, итгэл даах үүргээ зөрчөөгүй байна** гэж дүгнэсэн.

Делавер мужийн Дээд шүүхэд гаргасан гомдол: Нэхэмжлэгч нь анхан шатны шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглэхдээ буруу тайлбарлаж хэрэглэсэн хэмээн маргажээ.

Дээд шүүхийн шийдвэр³: Жишиг шүүхийн шийдвэрт⁴, төлөөлөн удирдах зөвлөл нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ үнэнч шударгаар шийдвэр гаргах тухай дурдсан байдаг. Тодруулбал, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр нь шударга байх (англ. Fair dealing), төлбөр тооцооны үнийн дүн бодит байх (англ. Fair price) гэсэн 2 үндсэн нөхцөлийг хангасан байх ёстой бөгөөд. Тус 2 нөхцөл бүрдсэн эсэхийг дараах үйл баримтад үндэслэн шалгажээ.

1. *Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд шахалт үзүүлсэн эсэх:* Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал болон хөрөнгө оруулалтын зөвлөх нарт холбогдох хэргийн үйл баримтаас үзэхэд Илон Маск нь Тесла компанийн төлөөлөн удирдах зөвлөлд СоларСити компанийг худалдан авах эсэхэд шахалт үзүүлээгүй байна. Мөн Илон Маск нь СоларСити компанийн өрийг төлөхийг хүссэн боловч төлөөлөн удирдах зөвлөлтэй өрийг төлөх талаар харилцан тохиролцоогүй байна. Иймд СоларСити компанийг худалдан авахаар болсон нь том хувьцаа эзэмшигч Илон Маскийг нөлөөлөөгүй гэж дүгнэсэн.
2. *Сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулсан хугацаа:* СоларСити компанийн санхүүгийн байдал хүндэрсэн учир Илон Маск СоларСити компанийг дампуурахаас сэргийлж худалдан авсан гэж маргадаг. Харин Тесла компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн компанийг шууд худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэлгүй, хөрөнгө оруулалтын зөвлөх хөлсөлж, тухайн компанийн магадлан шинжилгээг (англ. Due diligence)⁵ дуусахыг хүлээсэн. Мөн төлөөлөн удирдах зөвлөл Илон Маскийн санал болгосон хугацааг хүлээн авахгүйгээр компанийн магадлан шинжилгээг хүлээсэн нь үнэнч шударгаар шийдвэр гаргах нөхцөлийг зөрчөөгүй байна.
3. *Сонирхлын зөрчилтэй хэлцлийг удирдсан этгээд:* СоларСити компанийн худалдан авах ажиллагааг Тесла компанийн төлөөлөн удирдах зөвлөл

² Чансерийн шүүх нь Делавер мужийн анхан шатны шүүх бөгөөд тухайн мужийн өмчийн маргаантай холбоотой хэргийг хянан шийдвэрлэдэг. Үүнд: компани, өв залгамжлал, үл хөдлөх хөрөнгө, компанийн удирдлагын итгэл даах үүрэгтэй холбоотой маргаануудыг хянан шийдвэрлэдэг байна. Мөн Чансерийн шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргасан тохиолдолд Делавер мужийн Дээд шүүх хянан шийдвэрлэдэг.

³ Чансерийн шүүх болон бусад шүүхээс давж заалдах хэрэг маргааныг шийдвэрлэдэг давж заалдах шатны шүүх бөгөөд хэргийг эцэслэн шийдвэрлэдэг байна.

⁴ Weinberger v. UOP, Inc., 457 A.2d 701 (Del. 1983). <https://law.justia.com/cases/delaware/supreme-court/1983/457-a-2d-701-4.html> (last visited: 2026.02.24)

⁵ Компанийн худалдан авах ажиллагааны хүрээнд хэрэгжүүлдэг магадлан шинжилгээ нь худалдан авч буй компанийн санхүүгийн, хуулийн, үйл ажиллагааны болон стратегийн бүх талуудыг системтэйгээр шинжлэн үнэлж, эрсдэлийг илрүүлэх, шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах зорилготой шинжилгээний үйл явц юм.



зохион байгуулсан. Ингэхдээ төлөөлөн удирдах зөвлөлийн сонирхлын зөрчилгүй гишүүн Денхолм нь худалдан авах ажиллагааг удирдсан бөгөөд энэхүү ажиллагаанд Илон Маскийг оролцуулалгүй зохион байгуулсан байна.

4. *СоларСити компанийн нэгж хувьцааны үнэлгээ*: Төлөөлөн удирдах зөвлөл нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн бэлтгэсэн магадлан шинжилгээг үндэслэн санал болгосон анхны үнээс доогуур үнээр нэгж хувьцааг үнэлэн худалдан авсан. Иймд Тесла компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь үнэнч шударгаар шийдвэр гаргах нөхцөлийг зөрчөөгүй байна.
5. *Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүлээн зөвшөөрсөн эсэх*: **Жишиг шүүхийн шийдвэрт хэлцлийг баталсан процесс нь үнэнч шударгаар шийдвэр гаргах нөхцөлийн нэг хэлбэр гэж дүгнэсэн.** Тесла компани СоларСитиг компанийг худалдан авах эцсийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл бус, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр тухайн компанийг худалдан авсан. **Ийнхүү хувьцаа эзэмшигчдийн хуралд сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах бүх мэдээллийг үнэн зөв хүргэсэн учир үнэнч шударгаар шийдвэр гаргах нөхцөлийг зөрчөөгүй байна.**
6. *СоларСити компанийн нэгж хувьцааг шударгаар үнэлсэн эсэх*: Хэргийн нотлох баримт, хөрөнгө оруулалтын зөвлөхийн дүгнэлт, компанийн мөнгөн урсгал, шинжээчийн дүгнэлтийг дүгнэн үзэхэд Тесла компани СоларСити компанийн нэгж хувьцааг төлбөр тооцооны үнийн дүн бодит байх шалгуурт нийцүүлэн худалдан авсан байна.
7. Иймд Тесла компанийн том хувьцаа эзэмшигч болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ үнэнч шударгаар шийдвэр гаргах нөхцөлүүдийг хангаж, удирдлагын итгэл даах үүргээ зөрчөөгүй байна хэмээн дүгнэж анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.